

АШИГТ МАЛТМАЛЫН
ГАЗАР



АЛТ ОЛБОРЛОЛТ, ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Ашигт малтмалын газрын
Уул уурхай, судалгааны хэлтэс

Судалгааны ажлыг удирдсан:

АМГ, УУСХ -ийн дарга

АМГ, УУСХ, СМСТ-ийн дарга

АМГ, УУСХ, СМСТ-ийн ахлах мэргэжилтэн

Ц.Даваацэрэн

А.Бямбадагва

Ц.Цэгц

Судалж гүйцэтгэсэн:

АМГ, УУСХ, СМСТ-ийн мэргэжилтэн

Ч.Навчаа

Судалгааны ажлын талаархи санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38, АМГ,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр, Баруун жигүүр,
АМГ-ын байр Уул уурхай, судалгааны хэлтэс

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041

E-mail: navchaa68@yahoo.com

Web page: <http://www.mram.gov.mn>

АГУУЛГА

1. АЛТНЫ ҮНИЙН БАЙДАЛ -2011	4
2. ДЭЛХИЙН АЛТНЫ ОЛБОРЛОЛТ	6
3. ДЭЛХИЙН АЛТНЫ ХЭРЭГЛЭЭ	8
4. АЛТНЫ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ	10
5. МОНГОЛ УЛСЫН АЛТНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ	12
6. АМГ-АЛТНЫ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ	14
7. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ	15



1. СҮҮЛИЙН ҮЕИЙН ҮНИЙН БАЙДАЛ

2011 оны эхний 9 сарын байдлаар, Лондонгийн Металлын Биржийн алтны дундаж үнэ 1530 ам.доллар/унци болж 2010 оны дундаж үнэ 1225 ам.доллар/унцитай харьцуулахад 25%-р нэмэгдэж 10 жил дараалан алтны үнэ өсч байна. Эдийн засгийн сэргэлт зогсонги байдалд орж АНУ-н ажил эрхлэлтийн тухай сөрөг мэдээлэл болон Европын банкны сул байдал зэргээс шалтгаалан хөрөнгө оруулагчид найдвартай гэж үзэн алтыг худалдан авах нь нэмэгдсэнээр 2011 оны 9-р сарын 1-нд Лондонгийн Металлын Биржийн алтны үнэ анх удаагаа 1800 ам.доллар/унцид хүрч үнийн дээд хэмжээ тогтоосон. (Зургаг 1)

2011 оны 9-р сарын дундаж үнэ 1772 ам.доллар/унци болсон нь түүхэн дэх сарын хамгийн өндөр дундаж үнэ байсан боловч сүүлийн үед үнэ 1700 ам.доллар/унциас доош орсон. Лондонгийн биржийн алтны зах зээлийн өдөр бүрийн дундаж хэмжээ 9,4 сая унцид хүрч 2011 онд өнгөрсөн жилийн 8,4 сая унциас 12%-р илүү гарсан байна.

2009 оны эхээр 42 ам.доллар/баррел байсан газрын тосны үнэ 2010 онд тогтворжиж 75-90 ам.доллар/баррел-ийн хооронд зарагдаж байсан бол 2011 оны 4 сард 110 ам.доллар/баррелд хүрч үнийн оргилд хүрсэн ба 9 сарын дундаж үнэ 86 ам.доллар/баррел болсон. Алт газрын тосны үнийн харьцаа газрын тосны үнэ дээд цэгтээ хүрэхэд 13,4 болж буурсан ба газрын тосны үнэ буурахад 20-с илүү болж нэмэгдсэн. 2011 онд алт газрын тосны үнийн харьцаа 9-рсард 20,6 хүрсэн ба дунджаар 16,2 байсан. (Зургаг 2)

2010 оны тогтворгүй зах зээлийн байдал 2011 онд үргэлжилсэн ч 2010 оны 12-р сарын дундаж үнэ 1391 ам.доллар/унциас 2011 онд алтны үнэ жирийн байдалтай эхэлсэн. Хэдийгээр дэлхийн хөрөнгийн зах зээл уналтын байдлаас сэргэхээр харагдаж байсан ч ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр үлдэж зарим Европын банкуудын үйл ажиллагаа сайжирч чадаагүй.

Египет улсад 1 сарын сүүлчээр бослого үймээн эхэлж бүх бус нутагт тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэсэн. Үүний нөлөөгөөр алтны үнэ 1360 ам.доллар/унци болж 2,2%-р буурч харин газрын тосны үнэ их өөрчлөгдөхгүй 89 ам.доллар/баррель байсан. 2-р сард алтны үнэ 1373 ам.доллар/унцид хүрч 1% нэмэгдсэнээр үнэт металлын зах зээл дээрхи үнийн өсөлтийн анхны дохио байсан.

3-рсард Дундад дорнын үймээн зах зээлийг тодорхойгүй болгож газрын тосны үнийг 31 сарын хугацааны хамгийн өндөр үнэ болох 102 ам.доллар/баррель хүртэл нэмэгдүүлснээр алтыг найдвартай хөрөнгө гэж үзэх нь нэмэгдсэнээр алтны үнэ амжилт олж эхэлсэн. Энэ сард алтны үнэ 1424 ам.доллар/унци болсон. 4-р сард хөрөнгө оруулагчид дэлхийн эдийн засгийн байдлын талаар санаа зовниж алт худалдан авах нь үргэлжилснээр алтны дундаж үнэ 1474 ам.доллар/унцид хүрсэн. Ингэснээр долларын ханшны сулрал ба газрын тосны өндөр үнээс хөрөнгө оруулагчид ашиг олж байсан. 5 ба 6-р сард АНУ-н эдийн засгийн сэргэлт дэхь итгэл суларч Европын асуудлууд хямралын түвшинд ойртож алтны үнийн өсөлт

5-р сард 2,5%, 6 сард 1,2%-р нэмэгдэж алтны үнэ 1500 ам.доллар/унциас давж 5 сарын дундаж үнэ 1510 ам.доллар/унци, 6 сарын дундаж үнэ 1529 ам.доллар/унцид хүрсэн.


Хөрөнгийн зах зээлийн өсөлт ба шинжээчид үнэ тогтворгүй байна гэж анхааруулсныг үл харгалзан 7-р сард алтны үнэ үргэлжлэн нэмэгдэж дундаж үнэ 1573 ам.доллар/унци болсон. Португалийн өрийн зэрэг буурч Грекийн хямрал хүчтэй болсны дараагаар Европын бүсийн хямрал шинэ шатандаа орж байна гэсэн айдас нэмэгдсэн. 7 сарын сүүлчээр 2 дахь эдийн засгийн уналт бий болно гэсэн дэлхий нийтийн айдсаас шалтгаалан хөрөнгийн зах зээлийн байдал муудаж эхэлснээр алт биржээр арилжаалдаг сангийн хөрөнгө оруулалт нэмэгдэж найдвартай хөрөнгө гэж худалдан авах нь өссөн. 7-р сард алтны үнэ дахин 3%-р нэмэгдэж дундаж үнэ бараг 1573 ам.доллар/унцид хүрсэн.

8-р сард газрын тосны үнийн бууралт ирээдүйн эдийн засгийн өсөлтийн хувьд итгэлийг алдагдуулсан дохио болсон ба хөрөнгө оруулагчид буурч байгаа хөрөнгийн зах зээлээс хөрөнгөө бонд болон алт руу шилүүлэх нь үргэлжилсээр байлаа. Алтны үнэ 11%-с илүүгээр нэмэгдэж дундаж үнэ 1756 ам.доллар/унци болсон.


9-р сард, үргэлжилж буй эдийн засгийн сул үзүүлэлт, Европын өрийн хямрал ба буурч буй

хөрөнгийн зах зээл зэрэг нь алтны үнийг түүхэн дээд хэмжээ болох 1850 ам.доллар/унцид хүргэсэн, гэвч энэ нь удаан үргэлжлээгүй ба 1600 ам.доллар/унци хүртэл буурч сарын дундаж үнэ 1772 ам.доллар/унци болсон.

2011 оны эхний 9 сарын байдлаар алтны дундаж үнэ 1530 ам.доллар/унци болсон нь 2010 оны мөн үетэй харьцуулахад 30%-р нэмэгдсэн байна. 10 сарын байдлыг харахад алтны зах зээл чиглэлийн хувьд тодорхойгүй байгаа ба үнэ 1620-1660 ам.доллар/унцийн хооронд хэлбэлзэх хандлагатай байна.



(Зураг 1)




(Зураг 2)

2. ДЭЛХИЙ НИЙТИЙН АЛТ ОЛБОРЛОЛТ

3-р зурагт үзүүлснээр CPM судалгааны группийн мэдээллээс харахад 2010 онд дэлхий нийтийн алтны олборлосон бүтээгдэхүүн 78,4 сая унци болж 2009 онтой харьцуулахад 1,6%-р нэмэгдсэн. 2006-2008 онуудад 3 жил дараалан алтны олборлолт буурч байсан бол 2009-2010 онуудад дараалан алтны олборлолт нэмэгдсэн. Австрали улс нь дэлхийн алтны 2 дахь том олборлогч бөгөөд 2010 онд 8,3 сая/унци олборлож бараг 1,1 сая/унциар нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байсан. 2009 оны сүүлчээр дахин нээгдсэн Баруун Австрали дахь Newmont-ийн засвар хийгдсэн Bod-dington-ны алт зэсийн уурхайгаас 625000 унцийн өсөлт бий болсон. Хятад улс нь дэлхийн алтны хамгийн том олборлогч бөгөөд 10,96 сая/унци алт олборлож 8,6% (864000 унци)-р нэмэгдсэн. 3 дахь том олборлогч болох АНУ-н алтны бүтээгдэхүүн Nevada-ийн Barrick-ийн Cortez уурхайн бүтээгдэхүүн өссөнөөр 3,1% буюу 225000 унциар нэмэгдсэн. Дараагийн 5 том алт үйлдвэрлэгч орнууд болох Орос, Өмнөд Африк, Перу, Индонези ба Канад зэрэг орнуудын алт олборлолт гол уурхайнуудад хүдрийн агуулга буурснаас шалтгаалан 2010 онд бууралттай гарсан.

Зураг 3:




CPM Group-нь үргэлжилж буй алтны өндөр үнэ уурхай хөгжүүлэх ба үйл ажиллагаа явуулж буй уурхайд хийх өргөтгөлийн ажлыг хурдасгаснаар 2011 онд алтны уурхайн бүтээгдэхүүн 4,9 сая/унциар нэмэгдэнэ гэж үзэж байна. CPM Group-нь хэдийгээр сүүлийн жилүүдэд үйл ажиллагааны зардал нэмэгдэж байгаа боловч алтны үнийн огцом өсөлт үйлдвэрлэгчдэд бодит сайн үнэ өртөгийн зөрүүг бий болгосныг тэмдэглэсэн байна. Жишээ нь 2010 онд унци алтны үйл ажиллагааны зардал ойролцоогоор 544 ам.доллар байгаа нь 2002 оны зардалтай харьцуулахад 200%-р өссөн байна. Үйл ажиллагааны дундаж зардал ба алтны дундаж үнийн хоорондын зөрүү 2002 оны 114 ам.доллар/унциас бол 2010 онд 680 ам.доллар/унци хүртэл өссөн. MEG-ийн MineSearch мэдээллийн баазаас харахад жилд 5сая/унциас илүү бүтээгдэхүүн гаргах цогцолбор үйлдвэрлэлийн хүчин чадал бүхий 29 шинэ уурхай 2010 онд ашиглалтанд орсон. 2011 онд дэлхийн алтны үйлдвэрлэлд дараагийн 2 сая/унци алтыг жилд нэмэгдүүлэх 13 шинэ уурхай ашиглалтанд ороод байна.

Үүний үр дүнд, хүдрийн агуулгын үргэлжилсэн бууралт, үйлдвэрлэлийн тасалдал, уурхайн хаалтыг үл харгалзан 2011 оны дэлхийн алтны үйлдвэрлэл 2010 оны хэмжээнээс нилээд нэмэгдэх боловч 2001 онд олборлож байсан 81,3 сая/унциас бага зэргээр нэмэгдэнэ.



Зураг 4-д 2000-2011 оны дэлхийн алтны үйлдвэрлэл ба үнийн байдлыг үзүүлэв.

Зураг.4



Хүснэгт.1


Дэлхийн алтны нийлүүлэлт, 2001-2011 (сая/унци)

	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
УУ-н бүтээгдэхүүн	80.9	80.08	77.4	78.7	75.9	74.1	2008	77.2	78.4	83.3
Хаягдал	28	31.2	29.2	30.1	28.6	34.8	2008	43.1	42.2	43.1
Нийт	108.8	112	106.6	108.8	104.5	108.9	2008	120.3	120.6	126.4

Эх сурвалж: MEG's MineSearch database, CPM Group.

MEG-ийн MineSearch мэдээллийн баазаас харахад жилд нийтдээ 2 сая унци алт олборлох хүчин чадалтай 17 алтны уурхай 2011 оны сүүлчээр, жилд нийтдээ 4 сая/унциас илүү алт олборлох хүчин чадалтай 28 алтны уурхай 2012 онд ашиглалтанд орохоор жагсаасан байна. ТЭЗҮ-ийн шатандаа байгаа үйл ажиллагаа эхлэх нь албан ёсоор зарлагдаагүй байгаа 58 алтны шинэ уурхай 2011 ба 2012 онд үйлдвэрлэлээ эхлэхээр төлөвлөсөн байна. Тэдний нийт зарласан үйлдвэрлэлийн хүчин чадал жилд 8,1 сая/унци болох бөгөөд эдгээр ордууд нийтдээ 213 сая/унци алтны нөөцийг агуулж байна. Эдгээр 58 төслөөс Латин Америк нөөцийн 26% ба шинэ алт үйлдвэрлэх хүчин чадлын 25%-г, Хойд Америк алтны нөөцийн 19% ба шинэ хүчин чадлын 29%-г, Австрали нөөцийн 22%-г шинээр олборлох хүчин чадлын 13%-г, Африк нөөцийн 9%-г ба шинээр олборлох хүчин чадлын 12%-г, бусад үлдсэн хэсгийг нь Хуучин ЗХУ-н орнууд, Европ ба Ази номхон далайн бүс нутгийн орнууд тус тус эзэлж байна.

Алт олборлох шинэ хүчин чадал, бүс нутгаар, 2011-2012 он,
нийт: 8,1 сая.унци



3. ДЭЛХИЙ НИЙТИЙН АЛТНЫ ХЭРЭГЛЭЭ


Хэдийгээр алтны үнийн өндөр байдал ба дэлхийн эдийн засгийн сул байдал гоёл чимэглэлийг илүү үнэтэй болгосон ч эдийн засгийн сэргэлтийн шинж тэмдэг хэрэглэгчдийн хандлагыг сайжруулахад тусалснаар дэлхийн үйлдвэрлэлийн хэрэглээ 2009 онд 76,3 сая.унци 2010 онд 76,8 сая.унци болж бага зэрэг нэмэгдсэн байна. CPM Group-ийн Gold Yearbook 2011 -хэвлэлд дурдсанаар электроникийн салбарын хэрэглээ өссөн нь гол сайжралт байсан.

6-р зураг, 2-р хүснэгтэнд үзүүлсний дагуу үйлдвэрлэлийн хэрэглээний өсөлт нь 2 жил дараалан буурсан ба CPM Group нь 2011 онд Энэтхэгийн гоёл чимэглэлийн сорьц буурах хандлагатай байгааг үл харгалзан нийт үйлдвэрлэлийн хэрэглээ 80,7 сая.унцид хүрч 5%-р нэмэгдэнэ гэж үзэж байна.

Хэдийгээр алтны өндөр үнээс болж зарим хөрөнгө оруулагчид мөнгө хөрөнгөө дуусгаж байгаа ч 2011 онд хувийн хөрөнгө оруулалт 35,6 сая.унци болж 5,3%-р нэмэгдэх төлөвтэй байна.



Зураг 6:



1989 оноос 2007 он хүртэл 19 жилийн туршид цэвэр борлуулагч байсан төв банкууд 2009 оноос цэвэр худалдан авагч болсон. Хятадын ардын банк болон Энэтхэгийн нөөцийн банкаар тэргүүлүүлсэн төв банкууд өөрсдийн хөрөнгөө 2009 онд 17 сая.унци алтаар, 2010 онд 10,2 сая. унци алтаар нэмэгдүүлсэн байна. СРМ-нь 2011 онд цэвэр албан ёсны худалдаа 8-12 сая.унцид болох ба Оросын төв банк ба хөгжиж буй орнуудын алт худалдан авалт үүнд нэмэгдэж орно гэж үзэж байна.

Хүснэгт.2 Дэлхийн алтны хэрэглээ, 2002-2011 (сая/унци)

	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Электроник	4.9	5.1	5.3	6	8.1	9.6	9.6	8.3	9	9.7
Шүд/ Анагаах	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.4	2.3	2.2	2.1
Бусад үйлдвэрлэл	2	2	2	1.9	3.1	4.6	5.4	4.9	5	5.1
Гөёл чимэглэл	79.1	75.8	78.6	81	75.6	76.7	71.3	60.8	60.7	63.8
Нийт үйлдвэрлэл	88.5	85.4	88.5	91.4	89.3	93.5	88.8	76.3	76.8	80.7
Хувийн хөр/ оруулалт	32.8	44.9	35.6	40	26.8	33.6	26.9	27.3	33.8	35.6
Нийт бодит хэрэглээ	121.3	130.3	124.1	131.4	116.1	127.1	115.7	103.6	110.6	116.3
Албан ёсны борлуулалт	-11.9	-17.8	-16.6	-19.2	-11.7	-16.3	-0.1	17	10.2	10
Нийт хэрэглээ	109.4	112.5	107.5	112.2	104.4	110.8	115.6	120.6	120.8	126.3

4. АЛТНЫ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

London Bullion Market Association-аас алт, мөнгө зэрэг үнэт металлын 2011 оны дээд, доод ба дундаж үнийн хэтийн төлөвийн судалгааг металл-зах зээлийн шинжээчдийн групп хийж гүйцэтгэсэн байна. Алтны үнийн хэтийн төлөвийн судалгааг тайлангийн энэ хэсэгт үзүүлсэн.

Хэдийгээр 10 сарын өмнө энэ хэтийн төлөвийн судалгаа хийгдсэн ч графикт үзүүлснээр өнөөдрийг хүртэлх алтны дундаж үнээс хэр зэрэг ялгаатай байгааг нь харах нилээд сонирхолтой байна.

Шинжээчдийн группийн хийсэн хэтийн төлөвийн судалгаагаар 2011 оны алтны дундаж үнэ 1457 ам.доллар/унци, доод үнэ дунджаар 1268 ам.доллар/унци, дээд үнэ нь дунджаар 1633 ам.доллар/унци байна гэж таамагласан бол өнөөдрийг хүртэлх бодит дундаж үнэ нь 1530 ам.доллар/унци, доод үнэ нь 1360 ам.доллар/унци ба дээд үнэ нь 1772 ам.доллар/унци байна. Доор үзүүлсэн 23 үнийн таамаглалаас 1 нь өнөөдрийг хүртэлх бодит дундаж үнээс дээгүүр байгаа ба жилийн эцэс гэхэд үнийн байдал өөрчлөгдөн жилийн дундаж үнэ таамагласан хэтийн төлөвт ойртож очих хандлагатай байна. 2011 оны хэтийн төлөв болон одоогийн дундаж үнийн хоорондын зөрөө нь 73 ам.доллар/унци буюу 5% байна.

London Bullion Market Association-ний 2011 оны алтны үнийн хэтийн төлөвийн судалгаа

Шинжээчийн нэр	Компани	Дээд үнэ	Бага үнэ	Дундаж үнэ
Edel Tully	UBS	1700	1250	1550
Ross Norman	Sharps Pixley	1850	1350	1513
Frederic Panizzutti	MKS Finance	1780	1320	1502
Anne-Laure Tremblay	BNP Paribas	1650	1330	1500
Bayram Dincer	LGT Capital Management	1777	1222	1499
Suki Cooper	Barklays Capital	1620	1300	1495
Tom Kendall	Credit Suisse Securities	1630	1285	1490
David Jollie	Mitsui& Co Precious Metals	1610	1310	1485
David Wilson	Societe Generale	1550	1320	1485
Philip Klapwijk	GFMS	1673	1335	1447
Rene Hochreiter	Allan Hochreiter	1650	1350	1475
Matthew Turner	Mitsubishi Corp. Europe	1653	1270	1465
Michael Jansen	JP Morgan Securities	1650	1190	1463
Carl Firman	VM Group	1605	1250	1457
Jeffrey Rhodes	ITNL Commodities	1650	1150	1451
Jorg Ceh	Landesbank Baden-Wurttemberg	1700	1200	1450
James Steel	HSBC Bank USA	1550	1200	1450
Peter Fertig	QCRsearch	1550	1300	1450
Robin Bahar	Credit Agricole	1550	1280	1445
Daniel Smith	Standard Chartered	1550	1250	1400
Bob Takai	Sumitomo Corp	1590	1240	1390
Bhargava Vaidya	BN Vaidya&Associates	1550	1250	1375
Rohit Savant	CPM Group	1550	1280	1370
Wolfgang Wrzesniok	Rossbach-Heraeus	1550	1190	1325
Дундаж таамаглал		1633\$	1268\$	1457\$
2011 - дундаж үнэ		1772\$	1360\$	1530\$

2011 оны 9-р сард Montreal-д болсон чуулган дээрээ LBMA нь цахим систем ашиглан 2 өдрийн



чуулганы эхлэл ба төгсгөлд оролцогчдоос санал асуулга авсан. 530 төлөөлөгч саналаа өгсөн ба 2012 оны 11 сарын 5 гэхэд алтны дундаж үнэ 2075 ам.доллар/тн болно гэж үзсэн.

2 дахь санал асуулга чуулганы 2 дахь өдөр явагдсан ба тэр өдөр алтны борлуулагдсан үнэ 1803,5 ам.доллар/унци байсантай харьцуулснаар энэ удаа бага зэрэг буурч дундаж үнэ 2019 ам.доллар/унци болно гэж таамагласан. Эдгээр төлөөлөгчдийн дунд банкны болон худалдааны нийгэмлэгийн төлөөний хүмүүс, үйлдвэрлэгчид, зарим уул уурхайн болон цэвэршүүлж хайлуулах компаниуд ба бусад төлөөлөгчид оролцсон.

Ирээдүйд үнэт металлын үнэд нөлөөлөх боломжийн тухай сэдвээр тэдний үзэл бодлыг асуухад төлөөлөгчдийн 51% нь ирэх жилд долларын ханш суларч алтны үнэд нөлөөлнө гэж үзэж байхад 49% нь долларын ханш чангарна гэж хариулсан. Ирэх жилийн чуулган хийх үед Европын өрийн хямрал сайжрах уу эсхүл хүндрэлтэй болох уу гэсэн асуултын хариуд төлөөлөгчид адил хэмжээтэйгээр хуваагдсан байна. 2010 оны эцсээр Берлинд болсон LBMA-н чуулганы төлөөлөгчид нийтээрээ 2011 онд алтны үнэ 1450 ам.долларт хүрнэ гэж таамагласан байна.

Sharps Pixley-ийн шинжээч 10 сард алт болон хөрөнгийн зах зээл дээр хувирамтгай байдал бий болсноос хойш 2 сарын дараа жилийн эхээр хийсэн үнийн хэтийн төлөвөө дахиж хянаж үзэн зарим шинэчилсэн үнийн хэтийн төлөвөө мэдээлсэн. Тэрээр шинжээчид ерөнхийдөө алтны үнэ өсөх хандлагатай байна гэсэн үзэл бодлоо хэвээр хадгалж байгаа ба хэсэг шинжээчид 2012 оны алтны үнийн хэтийн төлөвийн таамаглалаа нэмэгдүүлсэн.

Bloomberg-ийн шинжээч 6 сарын 30-нд 1406 ам.доллар байсан 2012 оны алтны үнийн таамаглалаа 10 сарын 5-нд 27%-р нэмэгдүүлж 1781 ам.доллар/унци болно гэж мэдээлсэн. Мөн 10 сарын эхний 7 хоногт Natixis нь 2012 оны алтны үнийн хэтийн төлөвөө 1450 ам.доллар/унци болгож 11%-р нэмсэн бол Credit Suisse үүний дараа 2012 оны үнийн таамаглалаа 19%-р нэмэгдүүлж 1850 ам.доллар/унци болгосон байна.

Goldman үндсэндээ өөрчлөлт байхгүй гэж үзэн 1860 ам.доллар/унци гэсэн 12 сарын таамаглалаа дахин давтсан. BofA Merrill Lynch ба Barclays-ийн шинжээчид 2000 ам.доллар/унци гэсэн 12 сарын хэтийн төлөвөө хэвээр нь байлгаж байна. Barclays нь алтны үнийн өөрчлөлтийг түр зуурын үйлдэл буюу алт худалдан авах боломж гэж үзэж байхад Morgan Stanley судалгааны төв 2012 оны үнийн таамаглалаа 35%-р нэмж 2200 ам.доллар/унци болгосон.


Sharps Pixley нь 2008 оны эдийн засгийн уналтын үед хөрөнгө оруулагчид бусад хөрөнгө оруулалтын алдагдлаа нөхөхийн тулд алтаа ихээр борлуулснаар алтны үнэ 1000 ам.доллар/унциас 715 ам.доллар/унци болж буурсан ба сүүлд нь тэд буцааж алт худалдаж авснаар алтны үнэ буцаж нэмэгдсэн гэж дурдсан. Энэ үйл явдал өнөөдрийн байдалтай төстэй байгаа ба алтны бодит хэрэглээ их байхад биржээр зарагддаг фондын хөрөнгө тогтвортой байгаа нь алтны үнийг өсөхөд нөлөө үзүүлж байгаа ба энэ нь илэрхийгээр алтны үнийн бууралтыг хааж байна гэж үзсэн.

Дэлхийн банк, 2011 оны 10 сарын дундуур хэвлэгдсэн 2 сар тутмын **Commodity Prices and Price Indices** сэтгүүлдээ одоогийн Америк доллараар ирэх 5 жилийн алтны үнийг буурах хандлагатай гэж үзэн 2011 онд хамгийн өндөр 1475 ам.доллар/унци, 2012 онд 1350 ам.доллар/унци, аажмаар бууран 2016 онд 900 ам.доллар/унци болно гэж урьдчилан таамаглаж байна. Энэ урьдчилсан таамаглалдаа Дэлхийн банк ямар нэгэн тайлбар хийгээгүй байна.

Бээжинд байрлалтай Galaxy Securities компаний салбар, **Galaxy Futures**-ийн үнэт металлын шинжээч: Европын бүсийн өрийн асуудал ба АНУ-н холбооны нөөцийн шинэ эдийн засгийн хөнгөлөлтийн боломжит танилцуулга зэргээс шалтгаалан 2012 оны эцсээс өмнө алтны үнэ 2000 ам.доллар/унци хүртэл өснө гэж тооцож байна. Алтны үнэ 7 сарын эхнээс эхлэн Евро, үнэт цаас, өнгөт металл, иен ба доллараас хол илүү гарахад Galaxy нь 9 сарын алтны үнийн том уналтыг үл харгалзан алтны үнийн хэтийн төлөвийг өөдрөгөөр харж байна.

VTB Capital, нь **Commodities: Daily Trading Log**-ийн сүүлийн дугаарт: алтны богино хугацааны хэтийн төлвийн тухай АНУ-н долларын урсгал хүлээж байснаас их хэмжээгээр гарч ирснээр 9-р сарын сүүлчээр алтны найдвартай хөрөнгө гэсэн хандлагын зарим нь алдагдсан гэж дурджээ.

VTB одоогийн хөрөнгийн зах зээл дээр хийгдэж байгаа алтны худалдаатай АНУ-н доллар нь сөрөг хамааралтай байна гээд шинээр арга хэмжээ авахгүй бол алтны хэмжээ буурна гэж үзсэн. VTB: алтны дундаж үнэ богино хугацаанд 1680 ам.доллар/тн, дунд хугацааны үнэ бууран 1620 ам.доллар/унци болно гэж үзсэн.



Resource Capital Research (RCR), нь Overview and Investment Comment-н 2011 оны 9 сарын дугаартаа: Алтны үнэ 9сарын 5-нд нэрлэсэн хамгийн өндөр үнэ болох 1900 ам.доллар/унциас буурсан ч харьцангуй найдвартай хөрөнгө гэдэг байдлаараа алтны үнийн удаан хугацааны хэтийн төлөв эерэг байна гэдэгт итгэж байна гэж дурдсан.

9 сарын сүүлчээр 1850 ам.доллар/унциас илүү байсан алтны үнэ 1600 ам.доллар/унци болохоос өмнө **VM Group** нь 9 сарын 2011 ABN AMRO Metals Monthly сэтгүүлдээ дэлхийн эдийн засаг дараагийн бууралтын ирмэг дээр байна гэсэн айдсын дагуу АНУ болон Европын эдийн засгийн тухай сөрөг мэдээлэл нэмэгдсэнээр алтны үнэ хувирамтгайгаар худалдаалагдах үед шилжсэн гэж мэдээлжээ.

Өөр газрын алдагдлаа нөхөхийн тулд алтыг их хэмжээгээр худалдаалснаар хөрөнгийн зах зээл ихээр хямарсан. Гэсэн хэдий ч эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдсэнээр хөрөнгө оруулагчдын алтыг хадгалах сонирхол үргэлжилсээр байна. АНУ-н эдийн засгийн өсөлтийн тооцоогоор үнийг бууруулах талаар авч үзэх нь үргэлжилж байна.

Цагаан ордны Захиргаа удирдлага Төслийн хэлтсээс 2011 оны 2-р сард 2011 ба 2012 оны Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хэтийн төлөвийг 2,7% ба 3,5%-с мэдэгдэхүйцээр бууруулан тус бүрийг нь 1,7% ба 2,6% болгохоор зарласан.

Гэвч 9 сард Европын өрийн хямралын гол үе байсан. Европын төв банк хүүгээ бууруулах шахалтанд орж байх зуур өөр бусад орнууд дагаж хямрах айдастайгаар Грекийн өрийн хямралын тухай улам их бухимдалтайгаар зах зээл урагшилж байсан.

VM Group: өндөр инфляци ба ханшны үнийн бууралтаас хамгаалж Барууны зогсонги сул дорой эдийн засгийг буцааж өсөлтөнд оруулах ба өрийн хямралыг арилгах ямар нэгэн арга хэрэгсэл байгаа гэж үзэн алтны үнийн удаан хугацааны хэтийн төлөвийг сайжирна гэж үзэж байна.

АНУ-ийн эдийн засгийн хурдаа алдсан өсөлт, дараагийн мөнгөний бодлогын магадлал, Европын банкны хямрал, тэргүүлэх зах зээл дээр үргэлж буурч байгаа санхүүгийн баланс ба хөрөнгийн зах зээл дэх хямрал зэрэг нь алтыг найдвартай хөрөнгөөр хэвээр үлдэж байна.

Хэрвээ Грекийн өрийн болон Европын банкны асуудал шийдэгдэхгүй удааширвал алтны үнэ хамгийн өндөр үнэ болох 2000 ам.доллар/унцийн заагт ойртож очин шинэ дээд үнийн амжилтанд хүрнэ. **VM Group** нь 2011 онд алтны дундаж үнэ 1616 ам.доллар/унци, 2012 онд нэмэгдэн 1981 ам.доллар/унци, 2013 онд топ үнэ болох 2000 ам.доллар/унци болно гэсэн хэтийн төлөвийн таамаглал гаргасан.

5. МОНГОЛ УЛСЫН АЛТНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ


Монгол улс 2010 онд 6 тн алт 2011 оны эхний 11 сарын байдлаар 5 тн орчим алт олборлосон байна.

2010 онд Монгол улс 6 тн алт олборлосон нь дэлхий нийтийн алт олборлолтын 0,2%-г эзэлж байна. Энэ үзүүлэлт 2008 онд 0,6%, 2009 онд 0,4% байсан. Үүнээс харахад сүүлийн 5 жилд манай улсын алт олборлолт жил бүр буурч байгаа бөгөөд үүнд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар”-ын тухай хууль өнгөрсөн жилүүдэд нөлөөлж байсан бол энэ жилээс “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль” батлагдсан нь шууд нөлөөлж байна.


Гэсэн хэдий ч 2011 оны 01 сарын 01-ний байдлаар Монгол улсын ашигт малтмалын нөөцийн бүртгэлд давхардсан тоогоор 540 алтны шороон орд нийт 206,25 тн нөөцтөйгээр, 50 алтны үндсэн орд нийт 1278,2 тн нөөцтөйгээр бүртгэгдсэн байна.

Оюу толгой төслийн үйл ажиллагаа нь эхлэхээр жилд 544000 тн зэс, 650000 унци алт, 3 сая унци мөнгө олборлох ба энэ үед алтны олборлолтын хэмжээ нэмэгдэнэ гэж тооцож байна.

Зураг 7:



Зураг 8:



6. АМГ-АЛТНЫ ҮНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

2010 оны эхний хагаст алтны дундаж үнэ 1151,06 ам.доллар/унци байсан ба 2011 оны эхний хагаст 1444,12 ам.доллар/ унци болж 25%-р өссөн. 2011 оны 2-р улиралд алтны дундаж үнэ 1504 ам.доллар унци байсан бол 3-р улиралд 1699 ам.доллар/унци болж 13%-р нэмэгдсэн. 9 сарын дунд үе хүртэл алтны үнэ өдөр бүр шинэ амжилт тогтоож байсан ба 9 сарын 6-нд 1895 ам.доллар/унцид хүрсэн нь хамгийн өндөр үнэ байлаа.

Улс гүрнүүдийн тэргүүний үйлдвэрлэгч корпорациуд, банк санхүүгийн салбарынханы долларт итгэх итгэл суларсан ба үйлдвэрлэлийн үр өгөөж багасаж байгаатай холбоотойгоор зэсийн худалдаа удааширч, эсрэгээр эрсдлээс хамгаалахын тулд алт, мөнгө зэрэг үнэт металлыг сонирхох хандлага нэмэгдсэн болон АНУ болон Европын зарим улсуудын өрийн асуудал ба эдийн засгийн хямралаас болж буй долларын ханшийн сулрал, Хятад, Орос, Энэтхэг, Тайланд, Өмнөд Солонгос гэх мэт улсуудын Төв банкууд алт мөнгө зэрэг үнэт металлыг найдвартай хөрөнгө оруулалт гэж үзэх нь үргэлжилж ихээр худалдан авч байгаа нь үнэт металлын үнийн өсөлтөнд гол нөлөө үзүүлж байсан.


Харин 9 сарын дунд үеэс алтны үнэ буурч дундаж үнэ 1771 ам.доллар/унци болсон ба 10 сарын дундаж үнэ 1665,21 ам.доллар/унци болж 5,9%-р буурсан бол 2011 оны 11 сарын алтны дундаж үнэ 1738,98 ам.доллар/унци болж нэмэгдсэн.

Хөрөнгө оруулагчид үргэлжилж буй Европын өрийн асуудлыг шийдэх тухайд дахин эргэлзэж эхэлсэн учраас зах зээлийг тодорхойгүй болгож өнгөт болон үнэт металлын үнийн өсөлтөнд нөлөөлж байна. Хятад, Тайланд, Энэтхэг ба Индонези гэсэн Азийн худалдан авагчид алтны үнэ буурсан одоо үед зах зээл рүү буцаж орж ирвэл алтны үнэ дахин нэмэгдэнэ. Сүүлийн үед Грекийн өрийн асуудал дээр Испанийн санхүү, зээлийн асуудал үүссэнээр Европын бүсийн асуудал дахин хүндэрч үнэт металл болон бусад түүхий эдийн үнэ тогтворгүй хувирамтгай байхад нөлөөлж байна

2012 он гарсаар алтны үнэ өсч байгаа ба 1 сарын 31-нд 1744 ам.доллар/унцид хүрсэн нь 2011 оны 12 сарын 8-аас хойшхи хамгийн өндөр үнэ байлаа. 2012 оны 1-р улирлын алтны дундаж үнэ 1690 ам.доллар/унци байгаа нь 2011 оны 1-р улирлын алтны үнэтэй харьцуулахад 22%-р өссөн. Алтны үнийн энэ өсөлтөнд АНУ-н Холбооны нөөцийн газраас хийсэн мөнгөний хүүгийн хэмжээ 2014 оны сүүлч хүртэл доогуур хэмжээтэй байна гэсэн мэдэгдэл, долларын ханшны бууралт, ихэнх хөрөнгө оруулагчид нэмэгдэж буй инфляциас хамгаалахын тулд алтыг сонгож байгаа зэрэг нь нөлөөлж байна. Алтны дунд болон урт хугацааны үнэ өсөх хандлагатай байгаа бөгөөд 2012 онд 1600-1800, 2013 онд 1700-1900 ам. доллар/унцийн хооронд хэлбэлзэх хандлагатай байна.

2011он	Дундаж үнэ	Харьцуулалт	Өөрчлөлт
I улирал	1384		
II улирал	1504	II/I	9%
III улирал	1699	III/II	13%
IV улирал	1685.5	IV/III	-0.79%

Зураг 9:



7. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Ашигласан материал:

Metals Economics Group
 GFMS
 Kitco
 World Gold Council
 Монгол банк

<http://www.metalseconomics.com/>
<http://www.gfms.co.uk/>
<http://www.kitco.com/>
<http://www.gold.org/>
<http://www.mongolbank.mn/>

